



“Төрийн албан хаагчийн сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын журмын хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитын тайлан

Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн шалгалт, удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтад хамрагдаж, нөөцөд бүртгэгдээгүй 91 иргэнийг албан тушаалын сул орон тоонд томилсон байна.

Агуулга

Тайланг бэлтгэсэн:

Сэлэнгэ аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх
аудитор

Ч.Энхтуяа

Аудитын менежер

Б.Батмөнх

Ахлах аудитор

С.Бат-Эрдэнэ

Аудитор

Б.Эрдэнэзул

Ж.Цогт

З.Золбоо

2018 оны 12 сар

**Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70362442 дугаарын утас,
70363040 дугаарын
факсаар харилцана уу.**

**ХАЯГ:Сэлэнгэ аймаг,
Сүхбаатар сум, аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Төрийн албаны салбар зөвлөл нь төрийн албаны албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах, нөөцөд бүртгэх ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэж байна уу?

1.1 Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох мэргэшлийн шалгалтыг журмын дагуу, зохион байгуулж, гүйцэтгэж байна уу?

1.2 Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэх, нөөцийн сан бүрдүүлэх үйл ажиллагаанд холбогдох журмыг мөрдөн ажиллаж байна уу?

1.3 Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг холбогдох журамд нийцүүлэн сонгон шалгаруулж, үнэлгээ, дүгнэлт гаргаж байна уу?

1.4 Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг холбогдох журамд нийцүүлэн сонгон шалгаруулж байна уу?

2. Төрийн байгууллагууд төрийн албаны албан тушаалын сул орон тоог хууль, журмын дагуу нөхөн, томилж байна уу?

2.1 Албан тушаалын сул орон тооны захиалгыг ТАЗ-ийн Салбар зөвлөлд хүргүүлж байна уу?

2.2 Төрийн албаны албан тушаалын сул орон тоонд ТАЗ-ийн Салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн иргэнийг томилж байна уу?

3. Төрийн албаны албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хийгдэж байна уу?

3.1. ТАЗ-ийн Салбар зөвлөлийн төрийн албаны албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах, нөөцийн сан бүрдүүлэх, нөөцөөс нэр дэвшүүлэх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж байна уу

3.2 Төрийн байгууллагуудын төрийн албаны сул орон тооны захиалга өгөх, томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгдэж байна уу

Илрүүлсэн зөрчил

Аудитын дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагын саналд өгсөн тайлбар

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
БОАЖГ	Байгал орчин, аялал жуулчлалын газар
БСУГ	Боловсрол соёл, урлагийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ХАА	Хөдөө аж ахуй
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1.1. Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас Монгол Улсын Ерөнхий аудитор 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

1.2 Аудитын зорилт, хамарсан хүрээ

Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн (цаашид Салбар зөвлөл гэх) 2016-2018 оны 3 дугаар улирал дуусталх хугацааны төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтын журмын хэрэгжилтэд аудит хийж, гарсан зөрчлийг арилгах, санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Төрийн албаны салбар зөвлөл нь төрийн албаны албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах, нөөцөд бүртгэх ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэж байна уу?
- Төрийн байгууллагууд төрийн албаны албан тушаалын сул орон тоог хууль, журмын дагуу нөхөн, томилж байна уу?
- Төрийн албаны албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хийгдэж байна уу?

1.3 Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журам, АДБОУС 100, 400, 4100 дугаар стандартуудыг ашиглаж, Сэлэнгэ аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, сумын ТЭЗ, ЗДТГ-ын дарга нар болон холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, тус байгууллагуудын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, хугацаа

Дараах хууль эрхийн актуудыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын тухай хууль
- Дүрэм батлах тухай УИХ-ын 2009 оны 87 дугаар тогтоол
- Журам батлах тухай УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоол
- Журам батлах тухай МУЗГ-ын 2011 оны 62 дугаар тогтоол
- Төрийн албаны тухай хуулийн зарим зүйлийн заалтыг тайлбарлах тухай Улсын дээд шүүхийн 2010 оны 8 дугаар тогтоол
- Заавар батлах тухай ТАЗ-ийн 2013 оны 14 дүгээр тогтоол
- Журам, заавар батлах тухай ТАЗ-ийн 2013 оны 86 дугаар тогтоол
- Журам батлах тухай ТАЗ-ийн 2009 оны 99 дүгээр тогтоол
- Журам батлах тухай ТАЗ-ийн 2013 оны 128 дугаар тогтоол
- Журам батлах тухай ТАЗ-ийн 2013 оны 60 дугаар тогтоол
- Төрийн албаны Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн тогтоол, шийдвэрүүд.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор Б.Эрдэнэзул ахалж, ахлах аудитор С.Бат-Эрдэнэ, аудитор Ж.Цогт, З.Золбоо нар 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс 12 дугаар сарын 25-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэв.

1.4 Ерөнхий мэдээлэл

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2018 оны байдлаар 208 төр, төсвийн байгууллагад 6050 төрийн албан хаагч төрийн үйлчилгээг үзүүлж байна. Үүнээс 77.3 хувь буюу 4677 нь төрийн үйлчилгээний албан хаагч, 13.9 хувь буюу 843 нь төрийн захиргааны албан хаагч, 6.9 хувь буюу 419 нь төрийн тусгай албан хаагч, 1.8 хувь буюу 111 нь улс төрийн албан хаагч байна.

Аудитад Салбар зөвлөлд сул ажлын байрны захиалга өгдөг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний 16 хэрэгжүүлэгч агентлаг, 17 сумын орон нутгийн байгууллагууд зэрэг нийт 59 төр, төсвийн байгууллагын албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөнийг хамруулан авч үзлээ.

Түшиг сумын удирдлага нь аудитад шаардлагатай баримт материалыг аудитын хугацаанд ирүүлээгүй тул аймгийн салбар зөвлөлөөс авсан тоо, мэдээнд үндэслэн аудитад хамруулав.

Дээрх байгууллагуудад 2018 дугаар оны 3 улирлын байдлаар 1153 албан хаагч ажиллаж байгаа бөгөөд үүнээс удирдах албан тушаалтан 170 буюу 14.7 хувийг, төрийн жинхэнэ албан хаагч 509 буюу 44.1 хувийг, төрийн үйлчилгээний албан хаагч 359 буюу 31.1 хувийг эзэлж байгаа бөгөөд гэрээт ажилтан 117 буюу 10.1 хувийг тус тус эзэлж байна.

2016-2018 оны 3 улирлын байдлаарх бүрэлдэхүүн хөдөлгөөний судалгаагаар давхардсан тоогоор нийт 863 албан хаагч ажлаас чөлөөлөгдөж /өөрийн хүсэлтээр болон захиргааны санаачилгаар, өөр ажилд шилжсэн, хуульд заасан үндэслэлээр түр хугацаагаар чөлөөлөгдсөн зэрэг/, 999 албан хаагч /шинээр болон дэвшүүлэн томилогдсон, хуульд заасан үндэслэлээр авсан чөлөөний хугацаа дуусан эргэн томилогдсон зэрэг шалтгаанаар/ нөхөн томилогдсон байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

Үзүүлэлт	төрийн албан хаагчийн тоо			Бүрэлдэхүүн хөдөлгөөн			
	Нийт	Үүнээс		Шинээр болон бусад шалтгаанаар ажилд орсон хөдөлгөөн	Үүнээс		Ажлаас халагдсан болон бусад шилжилт хөдөлгөөн
		Удирдах	Төрийн захиргаа		Төрийн захиргааны албан хаагчийн ажилд орсон хөдөлгөөн	Удирдах ажилтны ажилд орсон хөдөлгөөн	
2016 он	1140	171	535	357	165	25	234
2017 он	1142	170	506	381	178	37	379
2018 он	1153	170	509	261	138	17	250
Нийт дүн				999	481	79	863

Нийт шинээр болон бусад шалтгаанаар ажилд томилогдсон албан хаагчдын 79 нь удирдах ажилтан, 481 нь төрийн захиргааны албан хаагчид байна.

Бүлэг 1

Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл нь төрийн албаны албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах, нөөцөд бүртгэх ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэж байна уу?

Сонгон шалгаруулалт огт зохион байгуулалгүйгээр төрийн үйлчилгээний зарим удирдах албан тушаалтны сул орон тоог нөхсөн бөгөөд төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн санг зохих журмын дагуу хөтөлж, бүртгээгүй байна.

1.1 Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдээс авах мэргэшлийн шалгалтыг зохион байгуулах комиссыг зохих журмын дагуу байгуулаагүй, мэдлэг хандлага зан үйлийг тогтоох буюу ярилцлагын шалгалтыг баримтжуулан архивлаагүй байна.

Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг аудитын хамарсан хугацаанд буюу 2016 онд 2, 2017, 2018 оны 3 дугаар улирлын байдлаар тус бүр 1 зэрэг нийт 4 удаа зохион байгуулсан байна. Дээрх шалгалтуудад давхардсан тоогоор нийт 67 байгууллагын 128 сул ажлын байр зарлагдаж, 89 ажлын байранд 898 иргэн бүртгүүлэн, 863 иргэн шалгалт өгсөнөөс 63 ажлын байранд 303 иргэн тэнцсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 2

Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход авсан мэргэшлийн шалгалт	Сонгон шалгаруулалт зарлагдсан		Бүртгүүлсэн ажлын байр, хүний тоо			Шалгалт өгсөн ажлын байр, хүний тоо						
	Байгууллагын тоо	Ажлын байрны тоо	Ажлын байр		Бүртгүүлсэн хүний тоо	Ажлын байр			Хүний тоо			
			Бүртгүүлсэн	Бүртгүүлээгүй		Нийт	тэнцсэн	тэнцээгүй	Нийт	тэнцсэн	тэнцээгүй	Үүнээс: Ур чадвараар
2018 оны 05 дугаар сард	25	48	31	17	105	31	20	11	100	47	53	10
2017 оны 10 дугаар сард	16	32	25	7	295	25	18	7	275	93	182	12
2016 оны 12 дугаар сард	12	27	18	9	286	18	14	4	277	96	181	11
2016 оны 05 дугаар сард	14	21	15	6	212	15	11	4	211	67	144	5
Нийт дүн	67	128	89	39	898	89	63	26	863	303	560	38

Шалгалт зохион байгуулах тухай бүр Салбар зөвлөлийн даргын шийдвэрээр томилсон ажлын хэсгүүд бүртгэлийн үйл ажиллагаа болон сорил, ярилцлагын шалгалтуудыг зохион байгуулж ирсэн бөгөөд шалгалт зохион байгуулахтай холбоотой гомдол санал гараагүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 5 дугаар бүлэгт заасны¹ дагуу мэргэшлийн шалгалт явуулах тухай бүр Салбар зөвлөлийн шийдвэрээр төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоонд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий салбар комиссыг 5-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр

¹ 5.3 ... аймаг, нийслэл дэх Салбар зөвлөлийн шийдвэрээр нутгийн захиргааны байгууллагын салбар комиссыг 5-9 хүний бүрэлдэхүүнтэйгээр мэргэшлийн шалгалт явуулах тохиолдол бүрт тус тус байгуулна.

байгуулах бөгөөд уг комисс нь бүртгэлийн болон сорилын, ярилцлагын ажлын хэсгийг байгуулахаар заажээ.

Уг салбар комиссын бүрэлдэхүүнд Салбар зөвлөлийн гишүүдээс гадна орон нутгийн холбогдох байгууллага, тухайн салбарын талаар мэдлэг, туршлагатай албан тушаалтныг оролцуулж болохоор² заасан байна.

Гэвч аймгийн хэмжээнд 2016-2018 оны 3 дугаар улирлын байдлаар 4 удаагийн шалгалт зохион байгуулахдаа салбар комиссыг байгуулалгүйгээр Салбар зөвлөлийн даргын шийдвэрээр бүртгэлийн болон сорилын, ярилцлагын шалгалтын ажлын хэсгийг байгуулж, гишүүдийг ихэнхдээ Салбар зөвлөлийн гишүүдэд багтдаг аймгийн ЗДТГ-ын ажилтнуудаар бүрдүүлж, бусад гишүүд болон холбогдох байгууллагуудын албан тушаалтныг хамруулаагүй байна.

Тухайлбал, 2016 оны 2 шалгалтын ярилцлагын шалгалтын ажлын хэсэгт Салбар зөвлөлийн гишүүн бөгөөд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, 2018 оны 1 шалгалтын ажлын хэсэгт Салбар зөвлөлийн гишүүн бөгөөд МХГ-ын даргыг оруулснаас бусад ажлын хэсгүүдийг Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд багтдаг аймгийн ЗДТГ-ын албан тушаалтнуудаар бүрдүүлж, Салбар зөвлөлийн бусад гишүүдийг оруулаагүй байна.

Ингэж мэргэшлийн шалгалтын салбар комиссыг Салбар зөвлөлийн бусад салбарын төлөөлөл болох гишүүдийн болон тухайн салбарын талаар мэдлэг, туршлагатай албан тушаалтны төлөөлөлгүйгээр явцуу хүрээнд зохион байгуулж байгаа нь төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдийг эрх тэгш, шударга өрсөлдүүлэн шалгаруулах үндсэн зорилгыг алдагдуулах, ашиг сонирхлын зөрчил үүсэх, тавигдсан ажлын байрны шаардлага хангахгүй иргэдийг сонгон шалгаруулах эрсдэлийг үүсгэж байна.

Мэргэшлийн шалгалтад хамрагдах иргэдийн бүртгэлийг хийхдээ Төрийн албаны зөвлөлөөс тогтоосон өдөр, цагт хүний нөөцийн системд нэвтрэх эрхийг нээн өгсөнөөр иргэдийн анхан шатны баримтыг үндэслэн, хүн нэг бүрээр шивж оруулдаг бөгөөд бүртгэлийн хувийн хэрэгт ирүүлсэн баримт материалыг тулган шалгаж, тэмдэглэл үйлдсэн “Бүртгэлийн хуудас”-ыг хавсаргадаг байна.

Өмнөх онуудад мэргэшлийн шалгалтад орохоор бүртгүүлсэн иргэдийн мэдээллийн бааз байхгүй байсан тул аудитын явцад 2018 оны 12 дугаар сарын 10-аас 14-ний өдрүүдэд шалгалтад орохоор бүртгүүлсэн иргэдийн материалуудаас түүвэрлэн үзэж, программаас баазыг хуулбарлан авч, тулган баталгаажуулж үзлээ.

Тус шалгалтад дэс түшмэлийн албан тушаалд 86, туслах түшмэлийн албан тушаалд 87 зэрэг нийт 173 иргэн бүртгүүлснээс дараах 4 ажлын байранд ажил олгогчийн ирүүлсэн захиалгын шаардлага хангаагүй иргэдийг бүртгэсэн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 3

д/д	Захиалга ирүүлсэн ажлын байрны нэр	Захиалгад ирүүлсэн шалгуур үзүүлэлт	Шалгуур зөрчиж бүртгэсэн үзүүлэлт
1	Статистикийн хэлтсийн мэргэжилтэн	Статистикч, эдийн засаг-Математик загварчлал	Нягтлан бодогч

² 5.3.2 Нутгийн захиргааны байгууллагын салбар комиссын бүрэлдэхүүнд Салбар зөвлөлийн гишүүдээс гадна орон нутгийн холбогдох байгууллага, тухайн салбарын талаар мэдлэг, туршлагатай албан тушаалтныг оролцуулж болно.

7.4. Ярилцлагын хэлбэрээр авах шалгалтын ажлын хэсгийг Салбар комиссын гишүүн ахлах бөгөөд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Салбар комиссын гишүүнээс гадна орон нутгийн холбогдох байгууллага, эсхүл тухайн салбарын талаар мэдлэг туршлагатай албан тушаалтныг оролцуулна.

2	Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч	Хүний их эмч	Нүүр ам судлалын их эмч
3	Цагааннуур сумын ЗДТГ-ын байгаль хамгаалагч	Төрийн захиргааны удирдлага, экологич, байгаль хамгаалагч	Агрофермерч
4	Шаамар сумын ЗДТГ-ын мэргэжилтэн	Малын эмч	Татварын эдийн засагч

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 7 дугаар бүлгийн 7.5-д заасны дагуу мэргэшлийн шалгалтыг ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох, ур чадварын түвшин тогтоох /Монгол хэл бичгийн мэдлэгийн болон албан хэрэг хөтлөх, Мэдээллийн технологийн/, мэдлэг хандлага зан үйлийг тогтоох гэсэн дарааллаар зохион байгуулсан байна.

Ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох болон ур чадварын түвшин тогтоох шалгалтыг Төв комиссоос тогтоосон өдөр, цагт, шалгалтын системийн сэлгээний программыг ашиглан гаргасан сорилгоор цахимаар авч, дүнг тухай бүрд нь гарган мэдээлжээ.

Харин мэдлэг хандлага зан үйлийг тогтоох шалгалтыг ТАЗ-өөс боловсруулж ирүүлсэн асуултын хүрээнд ярилцлагын хэлбэрээр авдаг ч 2017 онд авсан нэг удаагийн шалгалтад товч тэмдэглэл үйлдсэнээс бусдад нь иргэдээс авсан ярилцлагын тэмдэглэл хөтлөөгүй, шалгуулагчдын хариултыг цаасаар авч архивлаж хадгалаагүй байна. Энэ нь шалгуулагч иргэдийн үнэлгээг тодорхой бус болгож, иргэдийг үнэн зөв, шударгаар үнэлсэн эсэхийг нотлох боломжгүй болгож байна.

2016-2018 онд болсон 4 удаагийн ярилцлагын шалгалтад нийт 38 иргэн тэнцээгүй бөгөөд ерөнхий мэдлэгийн түвшин тогтоох болон ур чадварын түвшин тогтоох шалгалтад хамгийн өндөр оноо авсан иргэн ярилцлагын шалгалтад бага оноо авч, дараагийн байруудад жагссан байна. Үүнд:

- 2017 онд болсон Сайхан сумын Хот тосгоны үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр боловсруулах дэс түшмэлийн албан тушаалын ажлын байрны сорилын шалгалтад хамгийн өндөр оноо авсан иргэн ярилцлагын шалгалтад бага оноо авч 3-т жагссан,
- 2017 онд болсон Мандал сумын ЗДТГ-ын нийгмийн ажилтан, Баянгол, Хүдэр сумын төрийн сангийн мэргэжилтэн, Шаамар сумын нийгмийн даатгалын байцаагч зэрэг 4 туслах түшмэлийн албан тушаалын сорилын шалгалтад хамгийн өндөр оноо авсан иргэн ярилцлагын шалгалтад бага оноо авч 2-т жагссан,
- 2018 онд болсон аймгийн МХГ-ын ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын асуудал хариуцсан улсын байцаагчийн дэс түшмэлийн албан тушаалын сорилын шалгалтад хамгийн өндөр оноо авсан иргэн ярилцлагын шалгалтад бага оноо авч 2-т жагссан.

Дээрх тохиолдлуудад сорилын шалгалтаар 1-д жагсаж гарч ирсэн иргэн ярилцлагын шалгалтад үнэхээр тааруу дүн авч, нийт дүнгээр эзлэх байр ухарсан эсэхийг нотлох явцын тэмдэглэл, шалгуулагч иргэдийн хариултыг баримтжуулаагүй байгаа нь шалгуулагчдын нийт оноог ярилцлагын шалгалтын дүнгээр буюу шалгалтын комиссын бүрэлдэхүүнд орсон албан тушаалтнуудын үзэмжээр өөрчилж болох, өөрөөр хэлбэл ашиг сонирхлын зөрчил шууд үүсэх боломжийг үүсгэж байна.

1.2 Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэх, нөөцийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг холбогдох журмын дагуу хөтлөөгүй, зохих хяналтыг тавиагүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-д нутгийн захиргааны байгууллагуудын нөөцийн санг Салбар зөвлөлөөс харьяаллын дагуу эрхлэхээр заасан³ бөгөөд нөөцийн сан нь дараах 2 дэд бүтэцтэй байхаар заажээ. Үүнд:

- Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц /дотроо 4 төрлийн бүрэлдэхүүнтэй/
- Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөц /дотроо 4 төрлийн бүрэлдэхүүнтэй/.

Гэвч Салбар зөвлөлөөс зөвхөн “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-ийн бүртгэлийг шалгалт өгч тэнцсэн иргэдийн нөөцөөс бүрдүүлэн бүртгэж байна.

Аймгийн хэмжээнд 2018 оны 3 дугаар улирлын байдлаар дэс түшмэлийн албан тушаалд 105, туслах түшмэлийн албан тушаалд 120 иргэн нөөцөд бүртгэлтэй гэж бүртгэснээс нөөцөд байгаа, ажиллаж байгаа, 1-т жагссан бөгөөд өөрийн хүсэлтээр ажиллахаас татгалзсан, чөлөөлөгдсөн гэсэн 3 төрлийн ангиллаар бүртгэл хөтөлсөн байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 4

д/д	Шалгалт өгсөн он	Нөөцөд бүртгэлтэй иргэдийн тоо		Үүнээс:					
				Ажилд ороогүй нөөцөд байгаа		Ажиллаж байгаа		1-т жагссан бөгөөд өөрийн хүсэлтээр ажиллахаас татгалзсан, чөлөөлөгдсөн	
				дэс	туслах	дэс	туслах	дэс	туслах
1	2018	15	21	3	5	12	14		2
2	2017	38	55	11	14	26	39	1	2
3	2016	52	44			51	42	1	2
Нийт дүн		105	120	14	19	89	95	2	6

Харин төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний дараах 3 бүрэлдэхүүний нөөцийн бүртгэл хөтлөөгүй байна. Үүнд:

- төрийн төв байгууллагуудын болон нутгийн захиргааны байгууллагын санал, захиалгыг харгалзан тусгайлан зохион байгуулагдсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц;
- төрийн албаны ангилал нь өөрчлөгдсөний улмаас тухайн байгууллагын албан тушаалын ангилал нь төрийн жинхэнэ албан тушаал болж өөрчлөгдсөнтэй холбогдон зохион байгуулагдсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц;
- төрийн өндөр албан тушаалтны зэрэг зиндаа, түүнтэй адилтгах төрийн албан тушаалтны зэрэглэлд хамаарах улс төрийн албан тушаал эрхэлж байсан төрийн албан хаагчийг өөрийнх нь хүсэлтээр төрийн албаны төв байгууллагын шийдвэрийг үндэслэн бүртгэсэн төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц.

³ 1.5. Төрийн албаны зөвлөл нь яам, агентлаг, төр, засгийн удирдах дээд байгууллагуудын болон Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагуудын ажлын алба (цаашид “Төрийн төв байгууллагууд” гэх), аймаг, нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл (цаашид “Салбар зөвлөл” гэх) нь өөрийн харъяалах нутгийн захиргааны байгууллагуудын нөөцийн санг тус тусын харъяаллын дагуу эрхэлнэ.

Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн бүтцийг Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 2.2-т дараах 4 бүрэлдэхүүнтэй байхаар журамлан тогтоож өгсөн ч 2018 оны байдлаар аймгийн хэмжээнд гаргасан бүртгэл, мэдээлэл байхгүй байна. Үүнд:

- биеийн эрүүл мэндийн байдлын улмаас 1 жилээс дээш хугацаагаар албан ажлаа хийхгүйгээр эмчлүүлж, сувилуулах шаардлагатай болсон, гурван сараас дээш хугацааны сургалтаар (шинэ дадлага, туршлага эзэмшүүлэх сургалтыг оролцуулан) бэлтгэгдэх болсон, цэргийн жинхэнэ алба хаах болсон, захиргааны санаачилгаар түр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчийн нөөц;
- төрийн жинхэнэ албан хаагч төрийн улс төрийн албан тушаалд сонгогдон буюу томилогдон ажиллах болсон, эсхүл төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдон ажиллах болсон, тухайн төрийн байгууллага нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр татан буугдсан, бүтцийн өөрчлөлт орж орон тоо хасагдсан төрийн жинхэнэ албан хаагчийн нөөц;
- төрийн байгууллага татан буугдсан, өөрчлөн байгуулагдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо нь хасагдсан тохиолдолд 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэлэг авч, төрийн жинхэнэ албаны ямар нэгэн албан тушаалд ажиллахгүйгээр төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчийн нөөц;
- нөхөр (эхнэр) нь эрх бүхий байгууллагын томилолтоор өөр нутаг дэвсгэрийн нэгжид, мөн гадаад улс, олон улсын байгууллагад шилжин ажиллах болсон, эсхүл хүнд өвчтэй гэр бүлийн аль нэг гишүүнээ асрах зайлшгүй шаардлагын улмаас өөрийн санаачилгаар төрийн албанаас чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагчийн нөөц.

Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-ын 3 дугаар бүлэгт нөөцийн сангийн бүрдүүлэлт, хөдөлгөөний зохицуулалтыг журамлаж өгчээ.

Аймгийн хэмжээний “Нөөцийн сан”-ийн бүртгэл, бүрэлдэхүүн, хөдөлгөөнийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэж байгаа ч дараах зөрчилтэй асуудлууд ажиглагдаж байна. Үүнд:

- Зөвхөн төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт өгсөн иргэдийн мэдээллээр нөөцийн санг бүрдүүлдэг тул бусад шалтгаанаар /урт хугацаагаар эмчлүүлэх, сувилуулах, суралцах, цэргийн алба хаах болсон, улс төрийн болон төрийн үйлчилгээний албан тушаалд томилогдох болсон, байгууллагын бүтэц өөрчлөгдсөн, орон тоо хасагдсан, эрх бүхий байгууллагын томилолтоор өөр нутаг дэвсгэрийн нэгжид, гадаад улсын байгууллагад шилжин ажиллах болсон/ бүртгэлд байх буюу төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох хүртэл хязгаарлагдахгүй иргэдийн нөөцийн сан бүрдээгүй,
- Төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон иргэдийг нөөцөөс хасдаггүй, “ажиллаж байгаа” гэсэн тайлбартайгаар нөөцөд бүртгэлтэй байдаг,
- Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон нөөцийн бүртгэлийн хүчин төгөлдөр байх хугацаа дууссан талаар тухайн иргэнд хэрхэн мэдээлэл хүргэсэн талаарх мэдээлэл, түүнд хяналт тавьж баталгаажуулсан талаарх бүртгэл байхгүй,
- Нөөцөөс хассан иргэдийн бүртгэлийг тусад нь үйлдэж, архивт шилжүүлэн өгөөгүй байна.

Нөөцийн сангийн үйл ажиллагаанд Салбар зөвлөлийн дарга өдөр тутмын хяналт тавьж, зохион байгуулалтын удирдлагаар хангах ёстой ч бүрэлдэхүүн, хөдөлгөөнийг Салбар зөвлөлийн даргаар тухай бүр хянуулж батлуулсан, бүртгэлийг архивт шилжүүлэн өгсөн баримт материал байхгүй байна.

Энэ нь төрийн албан хаагчийн нөөцийн сангийн бүрэлдэхүүн, хөдөлгөөнийг зохих журмын дагуу хөтлөөгүй, түүнд тавих хяналт сул байгааг харуулж байна.

1.3 Зарим төрийн үйлчилгээний байгууллагуудын төсвийн шууд захирагч буюу удирдах ажилтны сул орон тоог сонгон шалгаруулалтгүйгээр нөхөн томилсон байна.

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 1.2-т заасны заасны дагуу⁴ төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтанд боловсрол, соёл урлаг, шинжлэх ухааны болон эрүүл мэнд, биеийн тамир, спортын зэрэг албан тушаалтнуудыг хамааруулахаар заажээ.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2016-2018 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 31 төсвийн шууд захирагч буюу төрийн үйлчилгээний байгууллагуудын дарга, захирал, эрхлэгч нарыг шинээр томилсон байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 5

2016-2018 оны 3 дугаар улирлын байдлаар шинээр томилогдсон удирдах албан тушаалтнуудын тоо	Төрийн үйлчилгээний салбар				Нийт дүн
	Боловсрол, соёл, урлаг	Эрүүл мэнд	Спорт	Тохижилт үйлчилгээ	
Сонгон шалгаруулалтад тэнцэж, томилогдсон	17				17
Сонгон шалгаруулалтад тэнцээгүй, түр томилогдон	5				5
Сонгон шалгаруулалтгүй шууд томилогдсон		7	1	1	9
Нийт дүн	22	7	1	1	31

Боловсрол, соёл, урлагийн салбарын 17 байгууллагын удирдах ажилтныг сонгон шалгаруулалтын үр дүнгээр жинхлэн томилж, 5 удирдах албан тушаалтан сонгон шалгаруулалтад тэнцээгүй тул даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч гэсэн тушаалтайгаар ажиллаж байна.

Харин эрүүл мэндийн болон спортын чиглэлийн төрийн үйлчилгээний байгууллагын 9 удирдах албан тушаалтны ажлын байрыг нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалт явуулалгүйгээр сумдын Засаг дарга нар шууд томилсон байна. Өөрөөр хэлбэл аймгийн Салбар зөвлөлөөс эрүүл мэндийн болон спортын салбарын төрийн үйлчилгээний дарга нарын бүрэлдэхүүн хөдөлгөөнд зохих хяналт хэрэгжүүлээгүй, сонгон шалгаруулалт явуулаагүй байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2018 оны байдлаар нийт 17 сум, 6 тосгоны 23 эрүүл мэндийн төвийн дарга, 8 өрхийн эмнэлгийн дарга ажиллаж байна.

Мөн уг журамд тусгайлан нэр заагаагүй гэсэн үндэслэлээр сум дундын ойн анги болон тохижилт үйлчилгээний газрын 3 удирдах албан тушаалтныг сумын Засаг дарга нар шууд томилсон байна.

Өөрөөр хэлбэл төсвийн байгууллагын шууд захирагчид буюу төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах үйл явц нь Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан журмын 1 дүгээр

⁴ 1.2.Удирдах албан тушаалд томилогдох ажилтанд Төсвийн тухай хуулийн 16.4.1-16.4.17-д зааснаас бусад боловсрол, соёл урлаг, шинжлэх ухааны болон эрүүл мэнд, биеийн тамир, спортын зэрэг албан тушаалтнуудыг хамааруулан ойлгоно.

зүйлийн 1.3-т заасан тухайн удирдах албан тушаалын шаардлагыг хангасан, төрийн албаны зорилт, чиг үүргийг мэргэжил, мэргэшлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх чадвартай төсвийн шууд захирагч, дарга, захирал, эрхлэгч нарыг сонгон шалгаруулж, томилох гэсэн гол зорилгыг бүрэн хангахгүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4.3-т заасны дагуу ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтыг аймгийн Боловсролын газар зохион байгуулж ирсэн бөгөөд яамдын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор 2015 оноос Боловсрол, соёл урлагийн газар болж, соёл урлагийн салбар шилжин ирснээр мөн байгууллагуудын удирдлагын сонгон шалгаруулалтыг явуулж байна.

Аймгийн боловсрол, соёл, урлагийн салбарт 2016 онд сонгон шалгаруулалт зарлагдаагүй бол 2017 онд 10 байгууллагын удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг 1 удаа, 2018 онд 15 удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг 4 удаа зохион байгуулсан бөгөөд нийт 23 ажлын байранд 35 иргэн өрсөлдөж, 16 ажлын байранд 19 иргэн тэнцсэн байна.

Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 6

Үзүүлэлт		2018 оны 3 дугаар улирлын байдлаар	2017 оны байдлаар	Нийт	
Сонгон шалгаруулалт зарлагдсан	Байгууллагын тоо	15	10	25	
	Ажлын байрны тоо	15	10	25	
Бүртгүүлсэн ажлын байр, хүний тоо	Ажлын байр	бүртгүүлсэн	13	10	23
		бүртгүүлээгүй	2		2
	Бүртгүүлсэн хүний нийт тоо	14	21	35	
Шалгалт өгсөн ажлын байр, хүний тоо	Ажлын байр	Нийт	15	10	25
		тэнцсэн	10	6	16
		тэнцээгүй	5	4	9
	Хүний тоо	Нийт	14	21	35
		тэнцсэн	12	7	19
		Үүнээс Ур чадвараар тэнцээгүй	7	13	20
		тэнцээгүй	7	14	21
Шалгалтын дүнг үндэслэн тухайн албан тушаалд томилсон	Байгууллагын тоо	10	6	14	
	Ажлын байрны тоо	8	6	14	

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 4 дүгээр бүлэгт заасны дагуу сонгон шалгаруулалт явуулах тухай бүрд аймгийн БСУГ-ын даргын шийдвэрээр дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй, төрийн бусад байгууллага, тухайн салбарын талаар мэдлэг туршлагатай албан тушаалтныг оролцуулан комисс байгуулахаар зохицуулжээ.

Гэвч сонгон шалгаруулах комисс байгуулаагүй байхад шалгалт зохион байгуулсан, сонгон шалгаруулах комиссыг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан,

зарим комиссын бүрэлдэхүүнд аймгийн Салбар зөвлөлийн гишүүд ордог, заримд нь ордоггүй зэрэг цаашид анхаарах, нэгдсэн зохион байгуулалт шаардлагатай болон засаж залруулах шаардлагатай асуудлууд ажиглагдлаа. Үүнд:

- 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Шаамар сумын Дулаанхаан тосгоны цэцэрлэгийн эрхлэгчийн албан тушаалын сонгон шалгаруулалтад сонгон шалгаруулах комисс байгуулаагүй бөгөөд аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, БСУГ-ын бодлого хэрэгжилтийн албаны дарга бөгөөд Монгол хэл, уран зохиолын боловсролын мэргэжилтэн, СӨБ-ийн мэргэжилтэн нарын 3 хүний бүрэлдэхүүн шалгалт авч, дүнг гаргасан байна. /Аудитын нөхцөл шаардлагын улмаас төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 11 сарыг дуустал хугацааг хамруулан, хөөн шалгасан болно./
- Сонгон шалгаруулалтын 2 удаагийн комиссыг БСУГ-ын хүний нөөцийн мэргэжилтэн болон боловсролын мэргэжилтнүүдээс бүрдсэн 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан.
- Нийт 4 удаагийн сонгон шалгаруулалтын комисс байгуулснаас 1-д нь аймгийн ЗДТГ буюу Салбар зөвлөлийн 2 гишүүнийг оролцуулсан бол бусдад нь БСУГ-ын мэргэжилтнүүдээс бүрдсэн комисс байгуулсан байна.

2018 оны 1 дүгээр сард зохион байгуулсан 1 удаагийн 8 удирдах ажилтны /Шаамар сумын 2-р цэцэрлэг, Ерөө, Түшиг, Мандал сумын Нархан, Номгон тосгон, Сүхбаатар сумын Хөгжилтэй одой цэцэрлэгийн эрхлэгч, Сант, Зүүнбүрэн, Мандал сумын 4-р сургуулийн захирал/ сонгон шалгаруулалтад Салбар зөвлөлийн гишүүн бөгөөд аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга, Хүний нөөцийн бодлого хариуцсан ажилтан нар оролцсон байна.

Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах комиссыг журамд заасны дагуу бус дээр дурдсан байдлаар тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан харилцан адилгүй бүтэц бүрэлдэхүүнтэй байгуулж байгаа нь мэргэжил, мэргэшлийн өндөр түвшний чадвартай ажилтныг сонгон шалгаруулах ажиллагаанд ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг дагуулж байна.

Аймгийн БСУГ-аас Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 5 дугаар бүлэгт заасны дагуу 8 төрлийн бичиг баримтыг тогтоосон хугацаанд хүлээн авч бүртгэдэг гэж байгаа ч бүртгэлийн хуудсыг хэвлэж баталгаажуулан, архивлаж хадгалаагүй байна.

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 6 дугаар бүлэгт заасны дагуу сонгон шалгаруулалтыг 9 хэлбэрээр зохион байгуулж үндсэн 3 үнэлгээгээр багцлан дүгнэж байна. Үүнээс ерөнхий шаардлагын буюу удирдах түвшний дараах 6 төрлийн шалгалтыг холбогдох журмын дагуу авч, үнэлж, дүгнэн баримт материалыг архивлан хадгалсан байна. Үүнд:

- Ерөнхий шаардлагын үнэлгээ буюу боловсрол, туршлага, мэргэшсэн байдлыг журмын дагуу үнэлж, дүгнэсэн,
- Удирдах ур чадварын буюу сорилын, мэдээллийн технологийн шалгалтыг Төв комиссоос тогтоосон өдөр, цагт, шалгалтын системийн сэлгээний программыг ашиглан гаргасан сориллоор цахимаар авч, бичгийн шалгалтыг албан бичиг хэрэг хөтлөлт, хэлний түвшин зэргээр кейс ажиллуулан дүгнэсэн байна.

Харин ярилцлагын буюу хөтөлбөр, төсөл бэлтгэлийн байдал, өргөдөл ирүүлсэн байдал, байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөр төсөл, өргөдлөө хэрхэн танилцуулсан байдал зэрэг 3 шалгалтыг ярилцлагын шалгалтын явцын тэмдэглэл, шалгуулагчийн шалгалтын материал зэрэг нотлох баримтаар баталгаажуулаагүй бөгөөд холбогдох баримт материалыг архивлаж хадгалаагүй байна.

Энэ нь ярилцлагын шалгалтад баримталсан чиглэл, шалгуур, үнэлгээ зэргийг тодорхойгүй болгож байгаагаас гадна ярилцлагын шалгалтын үр дүнгээр шалгуулагчийн нийт оноог үндэслэлгүйгээр дээш доош татах эрсдэлийг үүсгэж байна.

1.4 Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөхдөө холбогдох журмыг мөрдөөгүй бөгөөд сонгон шалгаруулалтад хамрагдаагүй иргэнийг албан тушаалд томилж байна.

Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-аар Төрийн захиргааны болон хуульд өөрөөр заагаагүй бол төрийн тусгай албаны удирдах албан тушаалд томилогдох⁵ ажилтныг хууль дээдлэх, шударга, ил тод байх, адил тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмаар сонгон шалгаруулахаар⁶ зохицуулагджээ.

Тус журмын 10 дугаар зүйлд⁷ заасны дагуу Салбар зөвлөлөөс сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга нар болон аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамрагдах хэрэгжүүлэгч агентлагуудын харьяа дээд байгууллагаас ирүүлсэн захиалгыг үндэслэн төрийн захиргааны удирдах ажилтнуудын албан тушаалтны сонгон шалгаруулалтыг явуулж байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2016-2018 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 24 удирдах ажилтныг шинээр томилсон бөгөөд үүнээс 12 албан тушаалтныг сонгон шалгаруулалтаар, 2 албан тушаалтныг төрийн захиргааны удирдах ажилтны нөөцөд бүртгэлтэй иргэдээс нэр дэвшүүлсэн бол Баянгол сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын сул орон тоонд сонгон шалгаруулалтад 1-ээр жагссан иргэн томилогдохоос өөрөө татгалзсан учир сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг томилсон байна.

Харин Бэлчир бүсийн болон Ерөө бүсийн Сум дундын ойн анги, аймгийн ХХААГ, ГХБХБГ зэрэг хэлтэс агентлагийн дарга, сумдын ХАА-н тасгийн даргын 2, Санхүүгийн албаны даргын 3 зэрэг нийт 9 удирдах албан тушаалтны ажлын байранд сонгон шалгаруулалт зохион байгуулалгүйгээр шууд томилсон байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 7

д/д	Үзүүлэлт	Аймгийн Салбар зөвлөлд сонгон шалгаруулалт зохион байгуулсан							Нийт дүн
		ИТХ-ын нарийн бичиг	ЗДТГ-ын дарга	БСУГ	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	ХХААГ	ГХБХБГ	Сум дундын ойн анги	
1	Сонгон шалгаруулалтад тэнцэж, томилогдсон	5	4	1	1				12
	- Үүнээс: Түр томилогдон ажиллаж байгаад шалгалт өгсний дараа жинхлэн томилогдсон	1	3	1	1				6

⁵ 1.Төрийн захиргааны болон хуульд өөрөөр заагаагүй бол төрийн тусгай алба (цаашид "Төрийн жинхэнэ алба" гэх)-ны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмыг баримтлана.

⁶ 4.Удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулахдаа хууль дээдлэх, шударга, ил тод байх, адил тэгш хандах болон нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно.

⁷ 10.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл /цаашид "Салбар зөвлөл" гэх/ нь энэ журмын 9-д зааснаас бусад удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулна.

2	Сонгон шалгаруулалт зохион байгуулж, нэр дэвшүүлсэн боловч томилоогүй	1							1
3	Нөөцөд бүртгэлтэй иргэдээс нөхөн томилогдсон		2						2
4	Сонгон шалгаруулалтгүй шууд томилогдон					1	1	2	5
Нийт дүн		6	6	1	1	1	1	2	5
									24

Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 5 дугаар бүлэгт сонгон шалгаруулах комиссыг шалгалт явуулах тухай бүрд нь Салбар зөвлөлийн шийдвэрээр комиссын дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулахаар заажээ.

Гэтэл аудитад хамрагдсан хугацаанд сонгон шалгаруулах комиссыг Салбар зөвлөлийн бус даргын шийдвэрээр салбар зөвлөлийн гишүүн буюу аймгийн ЗДТГ-ын мэргэжилтнүүдээс бүрдүүлж иржээ.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2016 оноос хойш нийт 13 удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах 6 удаагийн шалгалт зохион байгуулснаас комиссын даргаар аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, нарийн бичгийн даргаар хүний нөөцийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтнийг тухай бүр нь томилдог бөгөөд бусад гишүүнийг төрийн албаны салбар зөвлөлийн гишүүн болох Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд багтдаггүй Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга нараар бүрдүүлэн, ээлжлэн томилсон байна.

Аймгийн төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтыг сонгон шалгаруулах тухай бүрд Салбар зөвлөлийн даргын шийдвэрээр байгуулагдсан комиссын нарийн бичгийн дарга буюу Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга бүртгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Төрийн албаны зөвлөлөөс тогтоосон өдөр, цагт программын бүртгэл нээгдэж, шалгалтад оролцогчид биеэр бүртгүүлэн, давхар бүртгэлийн хуудас бүртгэн баталгаажуулсан байна.

УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 7 дугаар бүлэгт сонгон шалгаруулалтыг 2 үндсэн шалгаруулалтаар явуулж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлт гаргах заавар”-ын дагуу үнэлгээ, дүгнэлт өгөхөөр зохицуулсныг мөрдөж, холбогдох баримтыг архивын нэгж болгон хадгалсан байна.

Бүлэг 2

Төрийн байгууллагууд төрийн албаны албан тушаалын сул орон тоог хууль, журмын дагуу нөхөн, томилж байна уу?

Төрийн жинхэнэ албан тушаалын болон удирдах албаны сул орон тоог сонгон шалгаруулалтгүйгээр томилсон зөрчил оршиж байна.

2.1 Зарим агентлаг, орон нутгийн байгууллагууд сул орон тооны захиалгыг бүрэн ирүүлэхгүй байна.

Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд ажил олгогч Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1⁸, 17.4⁹ -д заасны дагуу тухайн байгууллагад ажиллаж байгаа болон бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас нөхөн томилох, боломжгүй нөхцөлд төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад орсон иргэдээс шалгаруулж авах хүсэлтээ төрийн албаны төв байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх замаар орон тоог нөхөхөөр хуульчилсан байна.

Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 17.1, 17.4-т заасны дагуу нөхөх боломжгүй тохиолдолд Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 2.1¹⁰-д заасны дагуу томилох эрх бүхий албан тушаалтан нь иргэнийг сонгон шалгаруулах захиалгыг ажлын байр тус бүрээр гарган ажлын байрны тодорхойлолтын хамт Салбар зөвлөлд хүргүүлэх үүрэгтэй.

2016-2018 оны 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор Салбар зөвлөлд 67 байгууллагаас төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын 128 сул ажлын байранд иргэнийг сонгон шалгаруулж авах захиалга ирүүлснийг тулган баталгаажуулалт хийхэд 11 байгууллага 15 ажлын байрны сул орон тооны захиалгыг Салбар зөвлөлд ирүүлээгүй байна. Үүнд:

Хүснэгт № 8

Байгууллагын нэр	Ажлын байрны нэр	тоо
Аймгийн ЗДТГ	Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн	1
Аймгийн ИТХ	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ хариуцсан мэргэжилтэн	1
БОАЖГ	Ойн менежмент, ойн нөхөрлөлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
БСУГ	Соёл урлагийн мэргэжилтэн	1
Статистикийн хэлтэс	Мэргэжилтэн	1
Орхон сум	Санхүүгийн албаны дарга	1
Орхонтуул сум	Санхүүгийн албаны дарга	1
	ХАА-н тасгийн дарга	1
Сайхан сумын ЗДТГ	2-р багийн нийгмийн ажилтан	1
	ХАА-н тасгийн мэргэжилтэн	1
Сайхан сумын Номгон тосгоны ЗАА	ХАА, үйлдвэрлэл дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн	1
Хүдэр сумын ЗДТГ	Төрийн сангийн мэргэжилтэн	1
Түшиг сумын ЗДТГ	Санхүүгийн албаны дарга	1
Шаамар сумын ЗДТГ	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	1
	Хөдөлмөр эрхлэлт хариуцсан мэргэжилтэн	1
Нийт		15

⁸ “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхөн”

⁹ “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 17.1-д заасан албан хаагчдаас нөхөх боломжгүй бол төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс уг албан тушаалд тавих онцлог шаардлагыг харгалзан шалгаруулж авах тухай хүсэлтээ төрийн албаны төв байгууллагад тавина.

¹⁰ Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.4-т заасны дагуу нөхөх боломжгүй тохиолдолд иргэнийг сонгон шалгаруулж авах захиалгыг байгууллага нь ажлын байр тус бүрээр гарган, Төрийн албаны зөвлөлөөс баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд тавигдах тусгай шаардлага”-д нийцүүлэн боловсруулсан Ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтын хамт энэхүү журмын 1.4-т заасан харьяаллын дагуу Төрийн албаны зөвлөл болон аймаг, нийслэл дэх Салбар зөвлөлд хүргүүлнэ”

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд УИХ-ын 2013 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 3 дугаар бүлгийн 14-д заасны дагуу тухайн байгууллагад ажиллаж байгаа болон төрийн бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас сонгон шалгаруулах замаар албан тушаал дэвшүүлэн болон удирдах албан тушаалтны нөөцийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдээс тухайн албан тушаалд тавих шаардлагыг харгалзан Салбар зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн уг тоог нөхөж болох бөгөөд дээрх 2 үндэслэлээр тухайн орон тоог нөхөх боломжгүй бол уг ажлын байранд ажиллах удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах захиалгыг ажлын байрны тодорхойлолтын хамт Салбар зөвлөлд ирүүлэхээр журамласан байна.

Аудитад хамрагдсан 2016-2018 оны 9 дүгээр байдлаар Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын 16 сул орон тоонд иргэнийг сонгон шалгаруулах захиалгыг томилох эрх бүхий албан тушаалтнаас Салбар зөвлөлд ирүүлсэн байна.

Аудитаар хийсэн тулган баталгаажуулалтаар Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын дараах сул орон тоонд иргэнийг сонгон шалгаруулах захиалгыг салбар зөвлөлд ирүүлээгүй байна.

- ГХБХБГ-ын дарга
- Баянгол сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга
- Бэлчир бүсийн сум дундын ойн ангийн дарга
- Ерөө бүсийн сум дундын ойн ангийн дарга.

Төрийн үйлчилгээний албаны удирдах ажилтны сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1-д заасны дагуу эрх бүхий этгээдээс тухайн ажлын байрыг нөхөх, сонгон шалгаруулах захиалгыг ажлын байрны тодорхойлолтын хамт Салбар зөвлөлд болон аймаг, нийслэлийн Боловсролын газарт харьяаллын дагуу ирүүлэхээр журамласан байна.

Салбар зөвлөлд болон Боловсрол, соёл урлагийн газарт 2016-2018 оны 9 дүгээр сарын байдлаар нийт 22 төрийн үйлчилгээний албаны удирдах томилогдох ажилтныг сонгон шалгаруулах захиалгыг ирүүлсэн байна.

Аудитын тулган баталгаажуулалтаар 2016-2018 оны 3 дугаар улирлын байдлаар Баянгол сумын Спорт цогцолборын дарга, Сүхбаатар сумын тохижилт, үйлчилгээний газрын дарга, 7 сумын ЭМТ-ийн даргыг шинээр томилсон боловч томилох эрх бүхий албан тушаалтнаас удирдах ажилтныг сонгон шалгаруулах захиалгыг Салбар зөвлөлд ирүүлээгүй байгаа нь Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1-д заасныг зөрчсөн байна.

Төрийн байгууллагуудаас сул орон тооны захиалгын хүснэгтийг судалгааны хэлбэрээр бөглөн албан бичгийн хамт Салбар зөвлөлд ирүүлж байгаа ч холбогдох журмын дагуу зайлшгүй дагалдах баримтуудыг ирүүлдэггүй, ирүүлсэн судалгааны хүснэгтийг Салбар зөвлөлөөс анхан шатны баримт материалтай тулган шалгаж, мэдээллийн үнэн зөвийг хянаж хүлээж авч хэвшээгүй байлаа.

Хүснэгт № 9

Аудитын явцад давхардсан тоогоор нийт 57 байгууллагаас ирүүлсэн 115 захиалгыг түүвэрт хамруулан, ирүүлсэн болон түүнийг хянаж авсан баримт материалыг тулган шалгаж үзэхэд албан ёсоор баталгаажсан ажлын байрны тодорхойлолтыг 5, сул орон тоо гарсныг нотлох шийдвэрийг 2 албан тушаалын захиалгад ирүүлсэн бөгөөд сул ажлын байр гарсныг нийтэд зарлаж, мэдээлсэн тухай баримтыг огт ирүүлээгүй байна.

Үзүүлэлт	Захиалга ирүүлсэн		Төрийн байгууллагаас ирүүлсэн захиалгад бүрдүүлж ирүүлсэн материал		
	Байгууллагын тоо	Ажлын байрны тоо	Ажлын байрны тодорхойлолт	сул орон тоо гарсныг нотлох шийдвэр	Нийтэд мэдээлсэн тухай баримт
2018 он	18	46	4	0	0
2017 он	17	18	0	0	0
2016 он	22	51	1	2	0
Нийт дүн	57	115	5	2	0

Аудитын дүнгээс харахад томилох эрх бүхий албаны тушаалтан нь сул ажлын байрны захиалгыг ирүүлэхдээ ажлын байрны тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг харилцан адилгүй боловсруулан ирүүлжээ.

Хэдийгээр төрийн байгууллагуудаас холбогдох зааврын дагуу¹¹ ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж байгаа ч тухайн албан тушаалд тавигдах нэгдсэн шаардлага, чиглэл байхгүй тул ажил олгогчийн өөрсдийн үзэмжээр тухайн хүнд тааруулан, тухай бүрд нь өөрчлөлт оруулан, боловсруулж ирүүлэх боломжтой байна. Тухайлбал:

- Сумдын ИТХ-ын нарийн бичгийн даргын 5 ажлын байрны захиалгыг харьцуулж үзэхэд:
 - Мэргэжлийн шаардлага дээр “Эрх зүйч”, “Эрх зүйч эдийн засагч”, “Хууль эрх зүйн болон удирдлагын ухааны мэргэжилтэй байх”, “Төрийн удирдлага болон бусад мэргэжлийнх байж болно”, “Төрийн удирдлага болон нутгийн удирдлагын менежер” гэсэн 5 өөр шаардлага тавьсан,
 - Мэргэшлийн шаардлагыг 3 ажлын байранд нь тавьсан,
 - Ажилласан жилийн шаардлагыг 1 нь “Төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх”, 3 нь “Төрийн албанд 5-аас доошгүй жил ажилласан байх”, 1 нь “Төрийн албанд 8-аас доошгүй жил ажилласан байх” гэсэн шаардлагыг тавьсан,
 - Ерөнхий болон тусгай шаардлагыг 1 нь 4, 3 нь 7-8, 1 нь 10 төрлөөр тавьсан.
- ЗДТГ-ын даргын 2 ажлын байрны захиалгыг харьцуулж үзэхэд:
 - Мэргэжлийн шаардлага дээр “эрх зүйч, эдийн засгийн болон нийгмийн салбарын мэргэжилтэй”, “Эрх зүйч эдийн засагч, багш” гэж заасан,
 - Ажилласан жилийн шаардлагыг “Төрийн албанд 8-аас доошгүй жил ажилласан”, “Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан” гэж заасан,
 - Ерөнхий болон тусгай шаардлагыг 1 нь 9, 1 нь 5 төрлөөр тавьсан.
- Малын эмчийн ажлын байрны 5 захиалгыг харьцуулж үзэхэд:
 - Мэргэшлийн шаардлагыг 1 нь заагаагүй, 1 нь “малынхаа чиглэлээр мэргэшсэн байж болно” гэж заасан бол 3 нь “мал эмнэлгийн анхан шатны, лаборатори сургалт эрдэм шинжилгээний чиглэлээр мэргэшсэн байх” гэж заасан,
 - Туршлагын шаардлагыг 2 нь “мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай байх”, 3 нь “Мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан байх” гэж заасан,
 - Ерөнхий болон тусгай шаардлагыг 2 нь 4, 3 нь 6 төрлөөр тавьсан.
- Төрийн сангийн мэргэжилтний 9 захиалгыг харьцуулж үзэхэд:
 - Мэргэжлийн шаардлага дээр 1 эдийн засагч бусад нь нягтлан бодогч, эдийн засагч гэж заасан,

¹¹ Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байрны тодорхойлолтын загвар”, “Ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт боловсруулах загвар”

- Ажилласан жилийн шаардлагыг 2 нь тавиагүй бол 3 нь “мэргэжлээрээ ажиллаж байсан туршлагатай”, 2 нь “1-ээс доошгүй жил мэргэжлээрээ ажилласан байх”, 2 нь “мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан байх” гэсэн шаардлагыг тавьсан,
- Ерөнхий болон тусгай шаардлагыг 5 нь 1-4, 4 нь 6-7 төрлөөр тавьсан.

2.2 Төрийн жинхэнэ албаны болон удирдах албан тушаалын сул орон тоог холбогдох хууль, журмыг зөрчин мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтад ороогүй, нөөцөд бүртгэгдээгүй иргэдийг түр болон жинхлэн томилж ажиллуулж байна.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-д “Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх хүсэлтэй, энэ хуулийн 10.1-д заасан ерөнхий болон 33.5-д заасан тусгай шаардлагыг хангасан иргэдийг өрсөлдүүлэн шалгаруулах зорилгоор тэднээс төрийн албаны мэргэшлийн шалгалт /цаашид “мэргэшлийн шалгалт” гэх/ авч онооны дэс дарааллаар төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэнэ. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний сонгон шалгаруулалтад тэнцэж, тухайн албан тушаалд тавигдах ерөнхий болон тусгай шаардлагыг хамгийн илүү хангаж байгаа нэг иргэнийг төрийн албаны төв байгууллага сонгон түүнийг томилох эрх бүхий этгээдэд нэр дэвшүүлнэ” гэж заасан байна.

2016-2018 оны 3 дугаар улирлын хооронд төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтыг нийт 4 удаа зохион байгуулахад 63 ажлын байранд 292 иргэн тэнцсэн байна. Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын гаргасан судалгаанаас үзэхэд 63 орон тоонд хамгийн өндөр оноо авч нэр дэвшсэн иргэний 41 нь тухайн албан тушаалдаа томилогдсон бол 22 иргэн өөрийн хүсэлтээр тухайн албан тушаалд томилогдохоос татгалзсан байна.

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3, 17.4-д заасныг зөрчин хэлтэс агентлаг, орон нутгийн байгууллага зэрэг нийт 35 байгууллага төрийн жинхэнэ албан тушаалд орох мэргэшлийн шалгалтад орж, нөөцөд бүртгэгдээгүй 72 иргэнийг түр тушаалаар томилон ажиллуулж байна. /Дэлгэрэнгүйг хавсралт № 1-д үзүүлэв./

Аудитын тайлагналын үе шатанд буюу 2018 оны 12 дугаар сард зохион байгуулагдсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтаар дээрх 72 орон тооны 51 ажлын байр нь зарлагдсан байна.

Хүснэгт № 10

Аудитад хамрагдсан хугацаанд Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийг бүрдүүлэх журам”-д заасны дагуу нөөцөөс нөхөх арга хэмжээг 5 удаа зохион байгуулж, 12 ажлын байранд шаардлагыг хангасан 12 иргэнийг нэр дэвшүүлэн эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж, томилуулсан байна.

Тайлант он	Ажлын байрны тоо	Нөөцөөс нэр дэвшүүлсэн иргэний тоо	Тухайн ажилд томилогдсон иргэний тоо
2016	2	2	2
2017	5	5	5
2018 оны 09 сар	5	5	5
Нийт дүн	12	12	12

Салбар зөвлөл нь Төрийн албаны тухай хууль болон УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах журам”-ын дагуу сонгон шалгаруулалтад тэнцэж, нөөцийн жагсаалтад орсон иргэдээс тухайн албан тушаалын шаардлагыг хамгийн сайн хангаж байгаа нэр дэвшигчийн талаарх санал дүгнэлтээ томилох эрх бүхий этгээдэд хүргүүлж ирсэн байна.

Салбар зөвлөлөөс 2016-2018 оны хооронд нийт 15 иргэнийг Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд нөөцөөс нэр дэвшүүлсэн бөгөөд үүнээс Баянгол сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд нэр дэвшүүлсэн иргэнийг тухайн байгууллага томилолгүйгээр, сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг томилсон бол бусад бүх нэр дэвшигчид тухайн албан тушаалд томилогдсон байна. Үүний 12 нь тухайн зарлагдсан албан тушаалын сонгон шалгаруулалтад 1-ээр шалгарсан иргэн байсан бол Сүхбаатар, Жавхлант сумын ЗДТГ-ын даргын сул ажлын байранд нөөцөөс нөхөн томилуулсан байна.

Хэдийгээр Салбар зөвлөл нь сул орон тооны захиалгын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгаруулалтад хамгийн өндөр үнэлгээ авсан иргэнийг томилох саналыг эрх бүхий этгээдэд нэр дэвшүүлж байгаа боловч аудитын явцад хийсэн тулган баталгаажуулалтаар Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөхдөө УИХ-ын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалтныг сонгон шалгаруулах журам”-ын 36, 38 дугаар зүйлд заасныг зөрчин сонгон шалгаруулалтад орж нөөцөд бүртгэгдээгүй 5 иргэнийг, тухайлбал аймгийн **ГХБХБГ-ын дарга, ХХААГ-ын дарга, Баянгол сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Бэлчир, Ерөө бүсийн сум дундын ойн анги** зэрэг байгууллагуудын даргаар шууд томилсон байна.

Мөн **Орхон, Орхонтуул, Түшиг сумдын Санхүүгийн албаны дарга, Орхонтуул, Зүүнбүрэн сумдын ХАА-н тасгийн дарга** зэрэг нийт 5 бүтцийн нэгжийн даргын албан тушаалд сонгон шалгаруулалтад орж нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг томилсон байна.

Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1.3-д заасны дагуу салбар зөвлөл болон аймаг, нийслэлийн боловсролын газраас сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдээс тухайн албан тушаалын шаардлагыг хангаж, хамгийн өндөр үнэлгээ авсан нэг иргэнийг дэвшүүлж, дүгнэлтийн хамт томилох эрх бүхий этгээдэд хүргүүлж томилуулсан байна.

Аудитад хамрагдсан хугацаанд Салбар зөвлөл, Боловсрол, соёл урлагийн газраас нийт 22 ажлын байранд сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан бөгөөд үүнээс шалгалтад тэнцэж хамгийн өндөр үнэлгээ авсан 17 иргэнийг төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд нэр дэвшүүлж, томилуулсан бол тэнцээгүй 5 иргэн түр үүрэг гүйцэтгэгчээр томилсон нь өнөөг хүртэл ажиллаж байна.

Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт № 11

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2¹², 8.4¹³ -д заасныг зөрчин нийт 9 иргэнийг Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд сонгон шалгаруулалтгүйгээр томилох шийдвэрийг гаргасан байна.

№	Байгууллагын нэр	Албан тушаал	Томилсон он
1	Баянгол сумын Спорт цогцолбор	Дарга	2017
2	Сүхбаатар сумын Тохижилт, үйлчилгээний газар	Дарга	2016
3	Баянгол сумын ЭМТ	Дарга	2017
4	Баруунбүрэн сумын ЭМТ	Дарга	2016
5	Орхон сумын ЭМТ	Дарга	2016
6	Орхонтуул сумын ЭМТ	Дарга	2016
7	Хүдэр сумын ЭМТ	Дарга	2017
8	Мандал сумын ЭМТ	Дарга	2016
9	Шаамар сумын ЭМТ	Дарга	2016

Дээрх байдлаас үндэслэн төрийн жинхэнэ болон удирдах албан тушаал, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөхдөө төрийн жинхэнэ албан тушаалд анх орох мэргэшлийн шалгалт болон удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг томилсон зөрчил оршсоор байна гэж дүгнэж байна.

Иймд Салбар зөвлөлийн зүгээс Төрийн албаны тухай хууль болон холбогдох журмуудыг зөрчсөн дээрх байгууллагуудын хууль бус томилгооны талаарх зөрчлийг арилгуулах арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах шаардлагатай байна.

Бүлэг 3

Төрийн албаны албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалт хийгдэж байна уу?

Төрийн албаны албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах үйл ажиллагаанд үр нөлөө бүхий хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.1 Төрийн албаны албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах, нөөцийн сан бүрдүүлэх, нөөцөөс нэр дэвшүүлэх зэрэг Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд ТАЗ-өөс хяналт шалгалт хийгдээгүй байна.

Аудитад хамрагдсан хугацаанд Төрийн албаны зөвлөлөөс Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд ямар нэгэн хяналт шалгалт хийгдээгүй бөгөөд 2016 онд 7, 2017 онд 20, 2018 онд 8 албан бичиг ирсэнийг тухай бүр нь хариуг хүргүүлж, ирсэн заавар, чиглэлийг хэрэгжүүлэн, хэрэгжилтийг тооцож, холбогдох мэдээ тайланг хүргүүлсэн байна.

Төрийн албаны зөвлөлөөс Салбар зөвлөлүүдийн үйл ажиллагааг жил бүр дүгнэж ирсэн бөгөөд Сэлэнгэ аймаг дахь ТАЗ-ийн Салбар зөвлөл нь 2015 онд 93.3 хувиар тэргүүлж байсан бол 2016 онд 79.6 хувиар дэд байр, 2017 онд 80.0 хувиар 5 дугаар байранд тус тус дүгнэгджээ.

¹² Томилох эрх бүхий этгээд нь Салбар зөвлөл буюу аймаг, нийслэлийн боловсролын газраас нэр дэвшүүлсэн иргэнийг тухайн албан тушаалд томилсон тухай шийдвэр гаргана.

¹³ Сонгон шалгаруулалтад ороогүй иргэнийг удирдах албан тушаалд томилохгүй

Гэвч ТАЗ-өөс ямар ажил дутуу хийгдсэн, цаашид ямар арга хэмжээ авч, үйл ажиллагааны хэрхэн засаж сайжруулах талаар тодорхой зөвлөмж, чиглэл өгөгдөөгүй байна.

Харин Авлигатай тэмцэх газраас 2018 оны 3 дугаар сард УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Салбар зөвлөлийн төрийн албаны албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах, нөөцийн сан бүрдүүлэх, нөөцөөс нэр дэвшүүлэх үйл ажиллагааг тодорхой хэмжээнд хянаж шалгаад дараах 2 зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

- *Иргэнийг хуульд заасан болзол, журмын дагуу төрийн албан орох адил тэгш боломжоор хангах, төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөхдөө хууль тогтоомжийн дагуу мэргэшлийн шалгалт өгөөгүй, төрийн албаны нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг томилдог зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахаас урьдчилан сэргийлэх, шинээр болон дэвшүүлэн томилохдоо мерит зарчмыг удирдлага болгох,*
- *Төрийн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсний улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх, хууль бус шийдвэр гаргасан тохиолдолд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэх.*

Аймгийн Салбар зөвлөлийн даргын зүгээс 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар тус газарт хариу хүргүүлсэн байна.

3.2 Төрийн байгууллагуудын сул орон тооны захиалга өгөх, томилох үйл ажиллагаанд Салбар зөвлөлийн зүгээс үр нөлөө бүхий хяналт шалгалт хийгдээгүй байна.

Салбар зөвлөлөөс эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын сул орон тооны захиалгыг хүлээн авахдаа баримт материал, мэдээллийн үнэн зөв эсэхэд хяналт тавьж хэвшээгүй байна.

Харин төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалт болон төрийн жинхэнэ, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн иргэдийг томилж, шийдвэрийг хэрэгжүүлж ажиллахыг захиалагч байгууллагуудад тухай бүр албан бичгээр хүргүүлж ирсэн байна.

Салбар зөвлөл нь 2016 оны 8, 2017 онд 7, 2018 онд 5 нийт 20 удаа хуралдаж дараах чиглэлийн асуудлуудыг шийдвэрлэж ирсэн байна. Үүнд:

- *Салбарын үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөө батлах тухай,*
- *Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд ирүүлсэн өргөдлийг шийдвэрлэх тухай,*
- *Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулах тухай,*
- *Төрийн албаны мэргэшлийн шалгалтын нөөцөөс нөхөх арга хэмжээнд материал ирүүлсэн иргэдийн хүсэлтийг шийдвэрлэх тухай*
- *Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэх тухай*
- *Удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнг хэлэлцэх тухай*
- *Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв олгох тухай.*

Салбар зөвлөлийн хуралдааны тэмдэглэлээс харахад эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд сул ажлын байрны захиалгыг бүрэн өгч байгаа эсэх, томилохоор хүргүүлж буй иргэнийг томилж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, үр дүнг хэлэлцээгүй байна. Хяналт шалгалт хийгдэж, үр дүнг тооцохгүй байгаагаас Салбар зөвлөлийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дараах зарчил гарсан байна. Үүнд:

- Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын 15, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын 4, төрийн үйлчилгээний албаны 9 зэрэг нийт 28 сул орон тооны захиалгыг ирүүлээгүй,
- Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалд төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалт өгч, нөөцөд бүртгэгдээгүй 77 иргэнийг томилсон,
- Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд сонгон шалгаруулалтад орж нөөцөд бүртгэгдээгүй 5 иргэнийг томилсон,
- Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд сонгон шалгаруулалтгүйгээр 9 иргэнийг томилсон зэрэг болно.

Салбар зөвлөлөөс 2018 онд төрийн байгууллагуудын төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ /мониторинг/¹⁴ хийсэн гэж байгаа ч үнэлгээ хийсэн ажлын тайлан, өгсөн зөвлөмж зэргийг баримтжуулаагүй байна.

ТАЗ-ийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2 дугаар бүлгийн 2.2.9-ийн 4 дэх зүйлд Салбар зөвлөл нь “албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учирсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах тухай саналаа Төрийн албаны зөвлөлд нотлох баримтын хамт хүргүүлэх, Төрийн албаны зөвлөл нь баримтыг нягталж үзээд шаардлага хангасан гэж үзвэл шүүхэд нэхэмжлэл гаргах буюу эрхийг шилжүүлж болно” гэж заасан боловч уг эрхийн асуудалтай холбоотой нэг ч ажил хийгдээгүй байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудаас ирүүлсэн судалгаагаар 2016-2018 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 17 байгууллагад 19 удаагийн шүүхийн шийдвэрээр үндэслэлгүй халагдсан ажилтнуудад 35,448.4 мянган төгрөгийн нөхөн төлбөр олгохоор тогтоогдсоноос Баянгол сумын ЗДТГ-ын дарга, Баруунбүрэн сумын ЭМТ-ийн эрхлэгч нар 2 удаагийн 5,875.1 мянган төгрөгийн нөхөн олговрыг төлж барагдуулсан /Дэлгэрэнгүйг хавсралт № 2-т үзүүлэв/ бол бусад нөхөн олговрыг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх ажил хийдээгүй байна. Үүнд:

- 11 удаагийн 23,253.5 мянган төгрөгийн нөхөн олговрыг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнуудаас бус төсвийн хөрөнгөөр нөхөн төлсөн,
- Хүдэр сумын Соёлын төвийн мэргэжилтэн, Ерөө сумын цэцэрлэгийн эрхлэгчид 6,261.0 мянган төгрөгийг нөхөн олговор олгохоор шийдвэрлэснийг өнөөг хүртэл шийдвэрлээгүй,
- Шаамар сумын ЭМТ, 2-р цэцэрлэг, Номгон тосгоны захирагчийн алба зэрэг 3 байгууллага шүүхийн шийдвэр гарсан гэж байгаа ч, хэрхэн шийдвэрлэж байгаа нь тодорхойгүй байна.

¹⁴ ТАЗ-ийн 2013 оны 128 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.3-т “төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ /мониторинг/, үнэлгээ хийж, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж гаргаж, холбогдох этгээдэд өгөх;”

Дүгнэлт

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Төрийн албаны албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах комиссыг Салбар зөвлөлөөс бус Салбар зөвлөлийн даргын шийдвэрээр байгуулж байна.
2. Ярилцлагын шалгалтын ажлын хэсгийг голчлон Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд багтдаг аймгийн ЗДТГ-ын ажилтнуудаас бүрдүүлж, бусад байгууллагын төлөөлөл болох гишүүд, тухайн салбарын талаар мэдлэг, туршлагатай албан тушаалтныг оруулаагүй байна.
3. Ярилцлагын шалгалтын явцын тэмдэглэл хөтлөөгүй, шалгуулагч иргэдийн хариултыг баримтжуулаагүй байгаа нь уг шалгалт үнэн зөв, шударга болсон эсэхийг нотлох боломжгүйд хүргэж байна.
4. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгэх, нөөцийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг холбогдох журмын дагуу хөтлөөгүй, зохих хяналтыг тавиагүй байна.
5. Байгууллагууд сул орон тооны захиалгыг Салбар зөвлөлд бүрэн ирүүлэхгүй байна.
6. Төрийн албаны удирдах албан тушаалтнуудын сул орон тоог нөхөхдөө сонгон шалгаруулалт хийлгүйгээр шууд томилж байна.
7. Зарим агентлаг, орон нутгийн байгууллагууд сул орон тооны захиалгыг бүрэн ирүүлээгүй, Салбар зөвлөл нь журмын дагуу анхан шатны баримтыг хянаж хүлээж аваагүй байна.
8. Зарим салбарын төрийн үйлчилгээний байгууллагуудын төсвийн шууд захирагч буюу удирдах ажилтны сул орон тоог сонгон шалгаруулалтгүйгээр нөхөн томилсон байна.
9. Төрийн байгууллагууд төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон удирдах, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалын сул орон тоонд төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалт, удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтад орж, нөөцөд бүртгэгдээгүй иргэнийг түр болон жинхлэн томилж байна.
10. Төрийн албаны албан тушаалын сул орон тооны захиалга өгөх, нөхөх, сонгон шалгаруулах, томилох үйл ажиллагаанд үр нөлөө бүхий хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Илэрсэн зөрчил

Хийж гүйцэтгэсэн аудитын дүнгээр илэрсэн дараах зөрчлүүдэд зөрчил арилгуулах, давтан гаргахгүй ажиллах зөвлөмж хүргүүлэв. Үүнд:

1. Төрийн жинхэнэ албаны сул орон тоонд төрийн жинхэнэ албанд анх орох мэргэшлийн шалгалт өгч, нөөцийн жагсаалтад бүртгэгдээгүй 77 иргэнийг томилсон.
2. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сонгон шалгаруулалтад ороогүй 5 иргэнийг удирдах албан тушаалд томилсон.
3. Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд сонгон шалгаруулалтгүйгээр 9 иргэнийг томилсон.

4. Байгууллагууд төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын 15, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын 4, төрийн үйлчилгээний албаны 9 зэрэг нийт 28 сул орон тооны захиалгыг Салбар зөвлөлд ирүүлээгүй.
5. Албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж, үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтны цалинг нөхөн олгоход 11 удаа 23,253.5 мянган төгрөг зарцуулсныг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга Ө.Сувдаад:

1. Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоонд анх орох болон төрийн захиргааны удирдах ажилтны сонгон шалгаруулалтын салбар комиссуудыг Салбар зөвлөлийн хамтын шийдвэрээр байгуулж байх.
2. Албан тушаалын сул орон тооны мэргэшлийн шалгалтын салбар комисст Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд багтдаг аймгийн ЗДТГ-аас бусад байгууллагуудын төлөөлөл болох гишүүд болон тухайн салбарын талаар мэдлэг, туршлагатай албан тушаалтныг оруулж байх.
3. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад захиалагч байгууллагуудын ирүүлсэн шаардлагад / *ажилласан хугацаа, мэргэжил зэрэг* / нийцсэн иргэдийг бүртгэж байх.
4. Мэдлэг хандлага зан үйлийг тогтоох буюу ярилцлагын шалгалтын явц, шалгуулагчдын хариултыг тэмдэглэл үйлдэж баталгаажуулах, архивлан хадгалах.
5. Ярилцлагын шалгалтын ажлын хэсэгт Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд багтдаг аймгийн ЗДТГ-аас бусад байгууллагуудын төлөөлөл болох гишүүд, тухайн салбарын талаар мэдлэг, туршлагатай албан тушаалтныг оруулж байх.
6. Төрийн жинхэнэ болон удирдах албан тушаалын ажлын байрны нөөцийн сангийн бүрдүүлэлт, хөдөлгөөнийг зохих журмын дагуу хөтөлж, түүнд тавих хяналтыг сайжруулах.
7. Төрийн байгууллагуудаас сул орон тооны захиалгыг холбогдох баримт материалын хамт хянаж хүлээн авч, бүртгэл хөтөлж байх.
8. Эрүүл мэнд, спортын салбарын болон бусад удирдах ажилтныг журмын дагуу сул орон тооны захиалгыг авч, сонгон шалгаруулж, нэр дэвшүүлж байх.
9. Салбар зөвлөлийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын сул орон тоог нөхөж буй үйл ажиллагаанд хяналт тавьж, төрийн жинхэнэ болон төрийн жинхэнэ албаны удирдах, төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд нөөцөд бүртгэгдээгүй иргэдийг томилсон зөрчлийг арилгах арга хэмжээ авах.
10. Албан тушаалтны хууль бус шийдвэрээр ажилтныг үндэслэлгүйгээр ажлаас халсан нь шүүхээр тогтоогдож, төрөөс нөхөн олговор олгосон талаарх судалгаа гаргаж, төрд учирсан хохирлыг буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээнд хяналт тавьж ажиллах.

Байгууллагуудын дарга, төсвийн захирагч нарт:

1. Сул орон тооны захиалгыг Салбар зөвлөлд тухай бүр бүрэн гүйцэт мэдээлэх.
2. Төрийн албаны сул ажлын байранд мэргэшлийн шалгалт, удирдах ажилтны сонгон шалгаруулалтад орсон, нөөцөд бүртгэгдэж, Салбар зөвлөлөөс нэр дэвшүүлсэн иргэнийг томилж байх.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
С.БАТ-ЭРДЭНЭ
Б.ЭРДЭНЭЗУЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛӨӨС ИРҮҮЛСЭН САНАЛ



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ

213200 Сүхбаатар, Сэлэнгэ аймаг,
Утас: 7036-3834

2018.12.26 № 160

танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА Ч.ЭНХТУЯА ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Танай 2018 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийгдсэн "Төрийн албан хаагчийн сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулалтын журмын хэрэгжилт" сэдэвт нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцан дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

Тайлбар 1-ийг үзнэ үү

Бүлэг-1 1.1-д "...Төрийн албанд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын ажлын хэсгийг байгуулахдаа гишүүдийн ихэнхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтнуудаар бүрдүүлсэн байна."

-Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга нар бүрэлдэхүүнд байдаг. Иймд ТАЗСЗ-ийн гишүүн, хэлтсийн дарга гэж тусгаж өгөх.

"...Төрийн албаны мэргэшлийн шалгалтын бүртгэлийг хийхдээ ирүүлсэн захиалгын шаардлага хангаагүй иргэдийг бүртгэсэн байна."

-Цагааннуур сумын ЗДТГ-ын байгаль хамгаалагч, ГХБХБГ-ын сумдын газрын даамал, Түшиг сумын Төрийн захиргаа, хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, Мандал сумын Хэрх тосгоны Захирагчийн албаны мэргэжилтэн, Шаамар сумын Нийгмийн даатгалын байцаагч нарын ажлын байранд тавигдах шаардлагад сумдад ажилласан жил, туршлага заадаггүй болно.

Тайлбар 2-ыг үзнэ үү

1.4-д "...Баянгол сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг зохион байгуулаагүй байна."

- 2016 онд Баянгол сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалын сонгон шалгаруулалтад 1 иргэн тэнцсэнийг Баянгол сумын ИТХ-ын дарга одоог хүртэл томилоогүй болно. ТАЗСЗ-ийн албан тоотоор захиалга ирүүлэхийг мэдэгдсэн боловч өнөөдрийг хүртэл ирүүлээгүй байна.

Тайлбар 3-ыг үзнэ үү

Бүлэг-2 2.2-т "...Сүхбаатар сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын сул ажлын байранд нөөцөөс нөхөн томилуулсан байна"

- Сүхбаатар сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын сонгон шалгаруулалтыг 2018 оны 5 сард удирдах ажилтны сонгон шалгаруулалтаар зохион байгуулж 1-ээр гарсан хүнийг нэр дэвшүүлэн томилсон.

Тайлбар 4-ийг үзнэ үү

Бүлэг-3 3.1-д "...Дотоод хяналт хязгаарлагдаж, Салбар зөвлөлөөс тавих дотоод хяналтын тогтолцоо алдагдсан байна"

Дээд байгууллагаас салбар зөвлөлд ирэх хяналт шалгалт ирээгүй байгаа бөгөөд хяналт шалгалтын ялгааг тодорхой болгох

ДАРГА



Ө.СУВДАА

Alban bichig My Doc A4

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛӨӨС ИРҮҮЛСЭН САНАЛД ӨГСӨН
ТАЙЛБАР**

Тайлбар 1: Саналыг хүлээн авч тайлангийн 1.1-д “ТАЗ-ийн Салбар зөвлөлийн гишүүн буюу аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга” гэж тодотгосон бөгөөд туслах түшмэлийн ажлын байранд ажилласан жилийн туршлага заасныг ТАЗ-ийн 2013 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 2.5-д “Туслах түшмэлийн ангиллын албан тушаалын сул орон тоонд ажилласан жилийн шалгуур үзүүлэлт тавихгүй.” гэж заасны дагуу залруулав.

Тайлбар 2: Саналыг хүлээн авч тайлангийн 1.4 дэх хэсэгт залруулав.

Тайлбар 3: Саналыг хүлээн авч тайлангийн 2.2 дахь хэсэгт залруулав.

Тайлбар 4: Аудитын тайлангийн 3.1-д “Төрийн албаны албан тушаалын сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулах, нөөцийн сан бүрдүүлэх, нөөцөөс нэр дэвшүүлэх зэрэг Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд ТАЗ-өөс хяналт шалгалт хийгдсэн эсэх талаар, 3.2 -т “Төрийн байгууллагуудын сул орон тооны захиалга өгөх, томилох үйл ажиллагаанд Салбар зөвлөлийн зүгээс хяналт шалгалт хийгдэж байгаа эсэх талаар” тодотгон оруулав.